**ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДЭД ЗӨВЛӨЛИЙН**
**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

**2024.11.15**

**Дорноговь аймаг**

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин | Хэрэгжилт |
|---|---|---|---|---|
| **Нэг. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг судалсны үндсэн дээр уг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд** | | | | |
| 1 | “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | “Хүүхдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж, насанд хүрээгүй хүүхэд гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болохоос сэргийлнэ | Журмын хэрэгжилт сайжирч, үр дүн гарсан байна. | Тус хэлтэс нь Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3-т заасны дагуу 16-аас доош насны хүүхдэд 5 жилийн хугацаатай гадаад паспортыг олгож байна. Үндэсний энгийн гадаад паспортыг олгохдоо Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6.2 дахь заалтад заасны дагуу 16-аас доош настай бол төрсний гэрчилгээ, түүний хууль ёсны төлөөлөгчийн иргэний үнэмлэх, эсхүл асран хамгаалагч, эсхүл харгалзан дэмжигчээр тогтоосон шийдвэрээр олгож байна. Тайлант хугацаанд 16 наснаас доош насны 3115 хүүхдэд үндэсний энгийн гадаад паспорт олгосон байна. |
| 2 | Цахим орчинд үйлдлэгдэж буй хүн худалдаалах, бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сэрэмжлүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэх | Цахим орчинд сэрэмжлүүлэг бэлтгэн, олон нийтэд хүргэсэн байна. | Улиралд 1-ээс доошгүй удаа, жилд 4-өөс доошгүй удаа сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулсан байна. | Тус хэлтсийн фэйсбүүк хуудсанд “Бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргээс хамтдаа урьдчилан сэргийлье, “Нэг л буруу алхам хийвэл буцаах боломжгүй” , “Цахим орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, “Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалцгаая” “намайг хамгаал” нөлөөлийн аяны хүрээнд хийгдэж буй шторк сэрэмжлүүлэг 8 мэдээллийг байршуулсан. |
| **Гурав. Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтаар хангах, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах хүрээнд** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Хүүхэд хууль бусаар үрчлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор гадаадын иргэнд үрчлэгдсэн хүүхдүүдэд тавих хяналтыг сайжруулах, | -. | | Тайлант хугацаанд гадаадын иргэн Монгол улсын харьяат хүүхдийг үрчлэн авах, Монгол улсын иргэн гадаадын иргэнтэй гэрлэсэн тохиолдол бүртгэгдээгүй байна. |

ТАЙЛАН БИЧСЭН: УЛСЫН БҮРТГЭГЧ Э.АРИУНТУЯА

ТАЙЛАН ХЯНАСАН: ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ТЭГШЖАРГАЛ

9029211
ГСТ7400 6623010010